ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 27 өдөр Дугаар А/31 Арвайхээр

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, 29.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил болгон зарлах тухай 03/06 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, мал аж ахуй, газар тариалан, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж ажиллахыг сумдын Засаг дарга, Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлагийн дарга нарт тус тус даалгасугай.

3.Зорилтот жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар ханган, хяналт тавьж ажиллахыг ажлын хороо (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА А.ИШДОРЖ

011100974

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2021 оны .01
дугаар сарын 27-ны өдрийн А/33 дугаар
захирамжийн хавсралт

“ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ” ЗОРИЛТОТ ЖИЛИЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Ажил, арга хэмжээ	Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Хугацаа	Хариуцах байгууллага
1. “ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ” жилийн ажлыг зохион байгуулах хорооны хэрэгжүүлэх арга хэмжээ				
1.1. Удирдлага зохион байгуулалтын талаар				
1.	Зорилтот жилийн ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулах	-	1 дүгээр сард	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /цаашид ХОХБТХ гэх/, аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар /цаашид ХХААГ гэх/
2.	Сумдын зорилтот жилийн ажлын төлөвлөгөөнд тусгуулах ажлын чиглэл хүргүүлж, төлөвлөгөөг хянаж, мэдээлэл зөвлөгөө хүргэх	-	1 дүгээр сард	ХОХБТХ, ХХААГ, сумдын Засаг дарга
3.	“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил”-ийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулах	Аймгийн төсөв	1 дүгээр сард	ХХААГ
4.	“Аймгийн газар тариалан эрхлэгчдийн зөвлөлдөх уулзалт”, “Аймгийн малчдын зөвлөлдөх уулзалт” зохион байгуулах, малчдыг “Аравт”-ын зохион байгуулалтад оруулах ажлыг судалж, эхлүүлэх	Аймгийн төсөв	2-3 дугаар улирал	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, ХХААГ, сумдын Засаг дарга
5.	“Төлчин сурагч”, “Туслах малчин”, “Намрын ажил” зэрэг арга хэмжээнд оюутан, сурагчдыг хамруулах, явуулын ном, соёлын үйлчилгээ үзүүлэх	-	1-4 дүгээр улиралд	ХХААГ, аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар, Политехник коллеж, сумдын Засаг дарга

6.	Хөдөө аж ахуйн салбарын ажилтан албан хаагчид, малчид, газар тариалан эрхлэгчид, үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх бүх төрлийн сургалтад хамруулах, туршлага судлуулах ажлыг зохион байгуулах	Аймаг, сумын төсөв	Жилдээ	ХОХБТХ, ХХААГ
7.	Малчид, тариалан эрхлэгчдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд нэгдсэн журмаар хамруулах	Аймгийн төсөв	2-3 дугаар улиралд	ХХААГ,Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
8.	Зорилтот жилийн хүрээнд “Хөдөлмөр зуслан”, шилдэг тариаланч, агрономич, малын эмч, малзүйч, үйлдвэрлэгч, аж ахуй эрхлэгч шалгаруулах уралдаан зарлаж, дүгнэх	Аймгийн төсөв	Жилдээ	ХХААГ, БСУГ
9.	Албан байгууллагын цайны газар болон нийтийн хоолны газруудад хуванцар шанага, сав, суулга хэрэглэхийг хориглох, айл өрхүүдэд дээрх савны хор хөнөөлийг таниулах, нөлөөллийн арга хэмжээг бүхий л төрлөөр зохион байгуулж, үр дүнг тооцох	-	1-4 дүгээр улиралд	МХГ, ХХААГ, сумдын Засаг дарга
10.	Зорилтот жилийн хүрээнд улирал бүр сонин гаргах	Аймаг, сумын төсөв	1-4 дүгээр улиралд	АЗДТГ, ХХААГ
	1.2. Мал аж ахуйн салбар			
11.	Монголын хоолойн тэмээ, Тээлийн улаан ямааны нутгийн шилмэл сүргийг омог болгон батлуулах ажлыг эхлүүлэх	Аймаг, сумын төсөв	Жилдээ	ХХААГ, сумын Засаг дарга
12.	Баянгол омгийн хонийг үүлдрээр, Уянгын сарлаг үхрийг омгоор баталгаажуулах судалгааны ажлын арга зүйг боловсруулан, батлуулах	Аймаг, сумын төсөв	Жилдээ	ХХААГ, сумын Засаг дарга
13.	Бог малын хээлтүүлэгчид хянан баталгаа хийж, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах	Аймаг, сумын төсөв	Жилдээ	ХХААГ, сумын Засаг дарга
14.	Хархорин, Хужирт, Баянгол сумдад “Бог малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж”-ийг байгуулах	Аймаг, сумын төсөв	3 дугаар улиралд	ХХААГ, холбогдох сумын Засаг дарга
15.	Хархорин, Хужирт, Баянгол сумдад битүү аргаар хурга засах, бордох ажлыг эхлүүлж, арга зүйгээр хангах	Аймаг, сумын төсөв	5 сард	ХХААГ, сумын Засаг дарга
16.	Газар тариалан бүхий нутаг, төв суурин газруудыг түшиглэн өндөр ашиг шимтэй мах, сүүний, хосолмол үхэр болон туслах аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Төсөл, хөтөлбөрийн хөрөнгө	Жилдээ	ХХААГ, сумын Засаг дарга
17.	Бэлчээр ашиглалтын аймгийн журам боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх	-	2 дугаар улиралд	ХОХБТХ, ХХААГ, сумдын Засаг дарга
18.	Аймгийн отрын бүс нутгийг шинэчлэн тогтоож, усан хангамжийг нэмэгдүүлэх	Улс, аймгийн төсөв, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө	Жилдээ	ХОХБТХ, ХХААГ, сумдын Засаг дарга

19.	Арвайхээр суманд аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн агуулах барих	Аймгийн төсөв, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө	Жилдээ	ХОХБТХ
20.	Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх чиглэлээр тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж малчдад үйлчилгээг хүргэх	Төсөл, хөтөлбөрийн хөрөнгө	Жилдээ	ХОХБТХ, ХХААГ, аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
21.	Мал эмнэлгийн нэгдсэн системийн үйл ажиллагааг өргөжүүлж, мал эмнэлгийн гэрчилгээг бичих, баталгаажуулах, хянахад шаардлагатай зарим төхөөрөмжөөр бүх сумын малын эмч, мэргэжилтнүүдийг ханган мал эмнэлгийн үйлчилгээг цахимжуулах ажлыг эхлүүлэх	Аймаг, смын төсөв	Жилдээ	Аймгийн Мал эмнэлгийн газар /цаашид МЭГ гэх/, сумдын Засаг дарга нар
22.	Мах, сүүнд антибиотикийн үлдэгдэл илрүүлэх шинжилгээний багажаар 6 сумыг хангах	Аймаг, сумын төсөв	Жилдээ	МЭГ, сумдын Засаг дарга
23.	Малчдыг малын эм, биобэлдмэлийг зохистой хэрэглэх арга зүйн талаарх сургалт, мэдээллээр хангаж, хяналт тавих	-	Жилдээ	МЭГ
24.	Мал сүрэгт тандалт шинжилгээ хийж, түүний дүнг үндэслэн тухайн бүс нутгийг мал, амьтны гоц халдварт өвчингүй тайван бүс болохыг баталгаажуулж, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг бүрдүүлэх	Аймгийн төсөв	Жилдээ	ХОХБТХ, МЭГ
25.	Экосистемийн дасан зохицох, сэргэх чадварыг дэмжиж, үүлэнд зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Аймгийн төсөв	1-3 дугаар улиралд	Ус, цаг уур, орчны шинжилгээний газар
1.3. Газар тариалангийн салбар				
26.	Зарим сумдад хүнсний ногооны төрөлжсөн зоорь шинээр барих, сэргээн засварлах, өвлийн хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Аймаг сумын төсөв, төсөл хөтөлбөр	Жилдээ	ХОХБТХ, ХХААГ
27.	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгуулж, Хархорин сум дахь гурил тэжээлийн үйлдвэрийг Хөдөө аж ахуйг дэмжих сангаас орон нутгийн өмчид шилжүүлэх авах, тариаланчдад газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийн үйлчилгээ үзүүлэх, бүх төрлийн таримлын үр үржүүлэх, аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	- Аймгийн төсөв -Хөдөө, аж ахуйг дэмжих сангийн техникийн дэмжлэг	Жилдээ	ХОХБТХ, ХХААГ
28.	Арвайхээр сумын Дайрга, Тарагт сумын Хүрэмт, Өлзийт сумын Хүйс, Баруунбаян-Улаан сумын Дөхөм, Хужирт сумын Нарийн цувриан тариалангийн талбайн услалтын системийн засвар шинэчлэл,	Аймаг, сумын төсөв, төсөл хөтөлбөр	Жилдээ	ХОХБТХ, ХХААГ, сумдын Засаг дарга

	Дайргын голын тариалангийн талбайг цахилгаанаар хангах ажлуудын хөрөнгийн эх үүсвэрүүдийг шийдвэрлүүлэх			
29.	Малын тэжээл тариалах аж ахуйн нэгж, иргэдэд үрийн дэмжлэг үзүүлэх	Аймаг, сумын төсөв	3-5 дугаар сар	ХОХБТХ, ХХААГ, сумдын Засаг дарга
30.	Тариалангийн талбайн өвчин, хортон шавьж, хог ургамлын төрөл зүйлийн тооллого, хөрсний агрохимийн шинжилгээ хийх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, зөвлөмж боловсруулж, хэрэгжүүлэх	Аймгийн төсөв	Жилдээ	МХГ, ХХААГ
31.	Аймгийн хэмжэээнд тариалангийн болон атаршсан газрын тооллого хийж, бүртгэлжүүлэх	Аймгийн төсөв	1 дүгээр улирал	ХОХБТХ, ХХААГ, ГХБХБГ, сумдын Засаг дарга
32.	Арвайхээр сумын Дайргын голын тариалангийн талбайд албан байгууллагуудын эзэмшдэг ашиглагдахгүй байгаа талбайг хурааж, тариалан эрхлэгчдэд эзэмшүүлэх	-	1-2 дугаар улиралд	ХХААГ, ГХБХБГ, сумын Засаг дарга
33.	Хүнсний бүтээгдэхүүнд иммуноферментийн аргаар хүнс болон мах, сүү, малын тэжээлд антибиотикийн үлдэгдэл, нимгэн үет хромотографийн багажаар төмс хүнсний ногоонд хлорорганик пестицид, бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүнд афлатоксин В1, В2, J1, J2, М1, М2, хлорторгарик тодорхойлох тоног төхөөрөмжөөр холбогдох байгууллагуудыг хангах	Аймгийн төсөв	Жилдээ	МХГ, МЭГ
34.	Хөдөө аж ахуйн машин, механизм, техник, тоног төхөөрөмжийн “Фарм шоу” үзэсгэлэн худалдаанд тариалан эрхлэгчдийг оролцуулах ажлыг бүхий л хэлбэрээр зохион байгуулах	Төсөл хөтөлбөр	Жилдээ	ХХААГ
1.4. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбар				
35.	Арьс, шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн зураг төсөв хийлгэх, шинээр барихад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх хүсэлтийг холбогдох газарт хүргүүлэх	Төсөл, хөтөлбөр	2 дугаар сард	ХОХБТХ, ХХААГ
36.	“Хамтдаа үйлдвэрлэлээ хөгжүүлье” бизнес экспо, “Төсөл, шинэ санаа сонгон шалгаруулах” арга хэмжээг шат дараалан зохион байгуулах	Аймгийн төсөв, төсөл хөтөлбөр	Жилдээ	ХОХБТХ, ХХААГ
37.	Сүү, дайвар бүтээгдэхүүн, яс, өөх, тос, өлөн гэдэс боловсруулах, малын тэжээл, борц, саван, цавуу, сав баглаа боодлын үйлдвэр байгуулах, хөрсгүй тариалан эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх	Аймаг, сумын төсөв	4 дүгээр сард	ХОХБТХ, ХХААГ, Агрономичдын холбоо
38.	“Өв эко мийт” орон нутгийн өмчит ХХК-ийг гадаад зах зээлд мах экспортлох магадлан итгэмжлэлтэй болоход дэмжлэг үзүүлэх	-	Жилдээ	ХОХБТХ, ХХААГ
39.	Арвайхээр хотод мал, малын гаралтай түүхий эдийн стандартын шаардлагад нийцсэн агуулах бүхий худалдааны төвтэй болоход аж ахуйн нэгж, иргэдэд дэмжлэг үзүүлэх	Төсөл хөтөлбөр	Жилдээ	сумдын Засаг дарга

40.	Төсөл хөтөлбөрүүд болон хөнгөлөлттэй зээлийн мэдээллүүдийг нэгтгэн олон нийтэд танилцуулах, хамрагдах боломжийг нэмэгдүүлэх	-	Сар бүр	ХХААГ, ХХҮГ
	2.Сумдын Засаг дарга нарын хэрэгжүүлэх арга хэмжээ			
41.	Сумдын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдийг үржлийн багажаар хангах	Сумын төсөв	Жилдээ	ХХААГ, сумдын Засаг дарга
42.	Бог малын хээлтүүлэгчийг Мал үржүүлэг, технологийн нэгжид ялган суурилж, стандарт, жишигт тэнцсэн өсвөр хээлтүүлэгчийг бойжуулан хээлтүүлэгт ашиглах	Сумын төсөв	Жилдээ	ХХААГ, сумдын Засаг дарга
43.	Уянга, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Хужирт, Хархорин сумд аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд өвс бэлтгэх хадлангийн талбайг шийдвэрлэх	-	Эхний хагас жилд	ХХААГ, сумдын Засаг дарга
44.	Сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг сайжруулан хэрэгжүүлэх	-	Эхний хагас жилд	сумдын Засаг дарга, аймгийн Бэлчээр ашиглагчдын холбоо /цаашид АБАХ гэх/
45.	Малчин өрх бүрт өөрийн өмчилж авсан өвөлжөө хаваржааныхаа 0.7 га газарт 0.1 га-аас хэтрүүлэхгүйгээр бэлчээрийн олон наст ургамлын үр цацаж тариалахыг зөвшөөрч, арга зүйгээр хангаж, үрийн дэмжлэг үзүүлэх	Сумын төсөв	Эхний хагас жилд	ХХААГ, сумдын Засаг дарга, АБАХ
46.	Зорилтот жилийн хүрээнд сум, баг, иргэдийн нөөц бололцоонд тулгуурлан “Хадлан тэжээл бэлтгэх”, “Хороо, бууцаа тохижуулах, барих, засварлах”, “Сүү, цагаан идээ, жимс, жимсгэнэ боловсруулах”, “Хуванцар савгүй өрх айл” зэрэг урамшуулалтай уралдаан зарлаж, дүгнэх	Сумын төсөв	Жилдээ	ХХААГ, сумдын Засаг дарга
47.	Шинээр малчин болж байгаа болон амьжиргааны түвшин доогуур малчин өрхийг малжуулах, өвөлжөө, хаваржаа, худаг устай болгох ажлыг зохион байгуулах	Сумын төсөв	Жилдээ	ХХААГ, сумдын Засаг дарга
48.	Сум бүр хөдөө аж ахуйд суурилсан брэнд бүтээгдэхүүнтэй болох, орон нутгийнхаа онцлогт тохирсон жижиг, дунд үйлдвэр, цех байгуулахад дэмжлэг үзүүлэх, сургуулийн үдийн цайнд орон нутагт үйлдвэрлэсэн цагаан идээг нийлүүлэх	Сум хөгжүүлэх сан, бусад эх үүсвэр	Жилдээ	Сумдын Засаг дарга
49.	Малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, даатгалд хамруулах арга хэмжээ авч, бэлчээрийн даацын хэтрэлтийг бууруулах	-	Жилдээ	ХХААГ, сумдын Засаг дарга
50.	Мал сүргийг ялган тэмдэглэж, ээмэгжүүлэн малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах ажлыг эхлүүлэх	-	Жилдээ	ХХААГ, сумдын Засаг дарга
51.	Бод малд GPS суулган байршлыг хянах ажлыг эрчимжүүлэх, малчдад сурталчилан таниулах	-	Жилдээ	ХХААГ, сумдын Засаг дарга

52.	Бүх сумд стандартын шаардлага хангасан мал нядалгааны цэг байгуулж, түүхий эдийн анхан шатны тордолтыг хийж, арьс, шир, нэхийг стандартын дагуу бэлтгэн нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, судлах	Сум хөгжүүлэх сан	Жилдээ	Сумдын Засаг дарга
53.	Атаршсан талбайг эргэлтэд оруулж, малын тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Сумын төсөв, Сум хөгжүүлэх сан, төсөл, хөтөлбөр	Жилдээ	ХХААГ, сумдын Засаг дарга
54.	Сонгино, саримсны тариалалтыг нэмэгдүүлж, орон нутгийн хөрсөнд тохирсон үрийн нөөцтэй болох	Сум хөгжүүлэх сан, төсөл, хөтөлбөр	Жилдээ	ХХААГ, сумдын Засаг дарга
55.	Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг Улаанбаатар хотын зах зээлд нийлүүлэхэд сумд хамтран ажиллаж, борлуулалтын цэгтэй болох	Сумын төсөв	Жилдээ	ХХААГ, сумдын Засаг дарга
56.	Арвайхээр, Хархорин сумдад малчны хороолол үүсгэж дэд бүтцийг шийдвэрлэх	Аймаг, сумын төсөв	Жилдээ	ГХБХБГ, сумдын Засаг дарга
3. Хөдөө аж ахуйн салбарын зөвлөлдөх дэд ажлын хэсгийн хэрэгжүүлэх арга хэмжээ				
57.	Сумдад жишиг хоршоог хөгжүүлэх, нэг сум, нэг хоршоо хөдөлгөөн өрнүүлэх, малын гаралтай түүхий эдийн анхан шатны тордолт хийх талаар малчид, түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдэд шат дараалсан сургалтууд зохион байгуулж, мэдээлэл, зөвлөгөө хүргэх	Аймгийн төсөв, Төсөл, хөтөлбөр	Жилдээ	ХХААГ, аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдийн холбоо /цаашид ХААХХ гэх/
58.	Мал нядалгааны стандартын шаардлага хангасан цэгийг сумдад бий болгох, түүхий эдийн анхан шатны тордолт хийх талаар мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх	Аймгийн төсөв	Жилдээ	ХХААГ, ХААХХ
59.	Малчдад мал маллагааны арга туршлагын, тариалан эрхлэгчдэд үр тариа, малын тэжээл, хүнсний ногооны тариалалт, хадгалалт, хамгаалалт, хөрс боловсруулалтын арга зүйн талаар тус тус зөвлөмж боловсруулан хүргүүлж, сургалтууд зохион байгуулах, мэдээлэл, зөвлөгөө хүргэх	Аймгийн төсөв	Жилдээ	ХХААГ, ХААХХ, аймгийн Агрономичдын холбоо, аймгийн Мал зүйчдийн холбоо
60.	Малчид, тариаланчдад малын тэжээлийн шимт чанар, тэжээл үйлдвэрлэх, мал тэжээх арга туршлагын талаар арга зүй боловсруулан хүргүүлж, мэдээ, мэдээллээр хангах	Төсөл, хөтөлбөр	Жилдээ	ХХААГ, ХААХХ, аймгийн Агрономичдын холбоо, аймгийн Мал зүйчдийн холбоо
4. Үйлдвэрлэл, хамтын ажиллагаа, цахим мэдээллийн дэд ажлын хэсгийн хэрэгжүүлэх арга хэмжээ				
61.	Зорилтот жилийн хүрээнд пэйж хуудас үүсгэн мэдээ, мэдээлэл, сургалт, арга туршлага, зөвлөмж, үйл ажиллагааны талаар баяжуулан хөтөлж, хөгжүүлэх	-	1 дүгээр сард	М.Нинж, Д.Цэвэлсүрэн

62.	Томоохон худалдааны төвүүдийн сүлжээгээр орон нутгийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулах ажлыг судалж хэрэгжүүлэх, иргэн, аж ахуйн нэгжүүдийг гадаад, дотоодын үзэсгэлэн худалдаанд цахимаар оролцуулах	-	Жилдээ	Ажлын хэсэг
63.	"Өвөрхангай түншлэл-2021", Шилмэл малын болон малын тэжээлийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	Аймгийн төсөв	9 дүгээр сард	ХОХБТХ, ХХААГ, Б.Уганбаяр, Д.Цэвэлсүрэн
64.	"Өвөрхангайд үйлдвэрлэв" логоны Brand book, цахим худалдааг хөгжүүлэх	Аймгийн төсөв, төсөл хөтөлбөр	Жилдээ	Ажлын хэсэг
65.	Төсөл, хөтөлбөрийн байгууллагуудад санал хүргүүлэх, хамтран ажиллах, санхүүжилт татах ажлыг зохион байгуулах	Аймгийн төсөв	Жилдээ	Ц.Навчаа, О.Гансүх Ц.Адъяа
66.	Томоохон төслүүдийг гадаад хэл дээр орчуулах, хөрөнгө оруулагчдад танилцуулах, гадаад орнуудтай үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагаа өрнүүлэх	Аймгийн төсөв	2 дугаар сард	Ц.Навчаа О.Гансүх
67.	Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах орон нутгийн үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах	Аймгийн төсөв	Жилдээ	Н.Гуамарал М.Нинж

-oOo-